



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/04

Арвайхээр сум

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2026 онд эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж нийлүүлэх тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Мөнгөнтуяа (Ахлах эм зүйч)

Нарийн бичиг: Э.Түмэнжаргал (Эдийн засагч)

Гишүүд: Д.Аззаяа (Сургалт хөгжил, бодлого төлөвлөлт,  
гүйцэтгэлийн албаны дарга)

Ц.Лувсандамдин (Эмнэлгийн тусламж үйлчилгээ,  
чанар аюулгүй байдлын албаны дарга)

Б.Пүрэвсүрэн (Аймгийн худалдан авах  
ажиллагааны газрын мэргэжилтэн)

Ч.Ганцэцэг (Либерал эмэгтэйчүүдийн оюуны  
сан төрийн бус байгууллагын өвөрхангай  
аймаг дахь салбарын зохицуулагч)

Т.Энхтайван (Иргэний төлөөлөл)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг үнэлгээний хороо дарга (Ц.Мөнгөнтуяа)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  ДАШЖАНЦАН

